



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

**Эмнэлгийн хэрэгслийн чанарын удирдлагын
тогтолцоо MNS ISO 13485:2021 стандартыг
шинэчлэн боловсруулах ажлын
хэсэг байгуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 12 дугаар зүйлийн 12.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн хэрэгслийн чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 13485:2021 стандарт”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, удирдамжийн дагуу ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Уранзаяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 010149